

БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

Огноо 2020-02-23

МНБ

Байгууллагын нэр

Зохион байгуулалтын нэгж,ажилтны нэр

Бүртгэсэн		Хаанаас	Баримт бичгийн		
Сар, өдөр <u>21</u> / <u>23</u>	Карт № <u>2104</u>	<u>Ард кредит</u> <u>ББСБ ХК</u>	Дугаар <u>1216</u>	Сар, <u>21</u> / <u>22</u>	Хуудасны ТОО <u>2</u>

Товч утга

Мэдээлэл хүлээн авах тухай

Удирдлагын

заалт.....

2020 он 12 сар 22 өдөр

Дугаар 1216.

Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-д

Мэдээлэл хүргүүлэх нь

Энэ өдрийн амгаланг айлтгая.

Ард Кредит ББСБ ХК нь 2019 оны 3 сард нээлттэй хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилж, холбогдох хууль тогтоомж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс баталсан дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.

Манай компанийн 5.2 хувийн хувьцааг эзэмшиж байсан хувьцаа эзэмшигч В.Баяржаргал компанид хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлт гаргасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 сарын 11-ний өдрийн ээлжит хурал болон 2020 оны 12 сарын 21-ний өдрийн эчнээ хурлаас хувьцаа эзэмшигч В.Баяржаргалаас нийт 418,570,880 (дөрвөн зуун арван найман сая таван зуун далан мянга найман зуун ная) төгрөгийн үнийн дүнтэй, 6,439,552 (зургаан сая дөрвөн зуун гучин есөн мянга таван зуун тавин хоёр) ширхэг хувьцааг (энэ нь нийт хувьцааны 2.29%), нэг бүрийг 65 (жаран тав) төгрөгөөр эргүүлэн худалдан авч, халааслах шийдвэр гарган хувьцаа эзэмшигчтэй харилцан тохиролцоод байна.

Уг шийдвэрийг гаргахдаа компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан Хувьцаа эргүүлэн худалдан авах зохицуулалт болон тус хуульд заасан журмын дагуу шийдвэрлэсэн бөгөөд компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авч холбогдох мэдээллийг 2020 оны 12 сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн сайтаар нийтэд мэдээлээд байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хувьцаа халааслах асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд энэ талаар мэдээллийг албан ёсоор Монголын хөрөнгийн биржид хүргүүлж байгаа тул уг мэдээллийг хөрөнгийн биржийн сайтаар мэдээ болгон гаргаж, нийт хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж өгнө үү.

Хавсралтаар Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ТЭЛМЭН



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 21-ний өдөр

Дугаар 2020/35

Улаанбаатар хот

Хувьцаа эргүүлэн
худалдаж авах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 12 сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигч В.Баяржаргалаас нийт 418,570,880 (дөрвөн зуун арван найман сая таван зуун далан мянга найман зуун ная) төгрөгийн үнийн дүнтэй, 6,439,552 (зургаан сая дөрвөн зуун гучин есөн мянга таван зуун тавин хоёр) ширхэг хувьцааг, нэг бүрийг 65 (жаран тав) төгрөгөөр эргүүлэн худалдаж авсугай.
2. Эргүүлэн худалдан авах нийт хувьцааны 2,224,167 ширхэг хувьцааг нэг бүрийг 65 төгрөгт тооцон 144,570,855 төгрөгийн хувьцааны арилжааг 2020 оны 12 сарын 22-ний өдөр хийж, үлдэх 4,215,385 ширхэг хувьцааг нэг бүрийг 65 төгрөгт тооцон 274,000,025 төгрөгийн хувьцааны арилжааг 2021 оны 2 сард багтаан тус тус хийхийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн эргүүлэн худалдан авсан хувьцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шилжүүлэн авч, компанийн халаасны хувьцаагаар бүртгэн, гэрээ, хэлцэл байгуулах, санхүүгийн гүйлгээг хийх, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгаж, хувьцаа эргүүлэн худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэлд компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д олгосугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдээллийг хүргүүлж, зөвшөөрөл аван хувьцаа эзэмшигчдэд хувьцаа эргүүлэн худалдан авахтай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (М.Мөнхсүрэн)-д даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороонд даалгасугай.

